



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ
АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛИЙН
2017 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН САНХҮҮГИЙН
ТАЙЛАНД ХИЙСЭН АУДИТ

Аудитын код: САГ-2018/117/СТА-ТӨҮГ

2018 он

01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ



YAG
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ИХ
СУРГУУЛИЙН 2017 ОНЫ ЖИЛИЙН
ЭЦСИЙН САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: САГ/2018/117/СТА-ТӨҮГ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Захиалагч:

Санхүүгийн аудитын газрын захирал бөгөөд
Тэргүүлэх аудитор Ц.Наранчимэг
Утас: 261663
Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер С.Оюунгэрэл
Утас: 261885
Цахим хаяг: oyungerels@audit.gov.mn

Аудитор Ц.Энхжаргал
Утас: 261740
Цахим хаяг: enkhjargalts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэгч:

"Хүлэгтхүннү Аудит" ХХК
Гүйцэтгэх захирал Е.Оюундэлгэр
Утас: 88084464; 70140505
Цахим хаяг: oyundelger@hulegthunnu.mn

Аудитор Ё.Наранбилэг
Утас: 88003980
Цахим хаяг: naranbileg@hulegthunnu.mn

Хаяг: Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сити тауэр, 10 давхар, 1001 тоот

*Аудитын газрын захиралын
төсөн мэдээлэл хийгч*

Ц. Наранчимэг

2018.12.28

Улаанбаатар хот



01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

**ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ**

Агуулга

1	Аудитын гэрчилгээ.....	2
2	Аудитын тайлан.....	1
2.1	Оршил.....	1
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага.....	1
2.3	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	2
2.4	Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	3
2.5	Дотоод хяналт.....	3
2.6	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	4
2.7	Шилэн дансны мэдээлэл.....	4
2.8	Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар.....	4
2.9	Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл.....	5
2.9.1	Биет бус хөрөнгийн талаар.....	5
2.9.2	Үндсэн хөрөнгийн талаар.....	5
2.9.3	Бараа материалын талаар.....	5
2.9.4	Авлагын талаар.....	5
2.9.5	Зардлын талаар.....	6
2.9.6	Өмчийн талаар.....	6
2.9.7	Өр төлбөрийн талаар.....	6
2.10	Анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	7
2.11	Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд.....	7
2.12	Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл.....	7
2.13	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	7
2.14	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	7
2.15	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	7
3	Менежментийн захидал.....	9
3.1	Биет бус хөрөнгийн талаар.....	10
3.2	Үндсэн хөрөнгийн талаар.....	11
4	Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	12
4.1	Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан.....	12
4.2	Аудит хийгдсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	14
4.3	Аудит хийгдсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	16
4.4	Аудит хийгдсэн цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлтийн тайлан.....	18
4.5	Аудит хийгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	19





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62 26-32-30
E-mail: info@audit.gov.mn

ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН
ИХ СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.ОЧИРБАТ ТАНАА

2018.03.29 № 06/863
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

010.10.10.20\Bichig_Kherig\Yawsan_Bichig\2018\0328SAG11.Docx

01

091547
ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА
ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН ЗАХИРАЛ
БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

\\10.10.10.20\Bichig_Kheregi\Yawsan_Bichig\2018\0328SAG11.Docx



01

ТӨРИЙН АУДИТЫН БАЙГУУЛЛАГА

ЗӨРЧИЛГҮЙ
САНАЛ ДҮГНЭЛТ

2 Аудитын тайлан

2.1 Оршил

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайланг захирал Б.Очирбат танд танилцуулж байна.

Энэхүү тайланд танай байгууллагын санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Менежментийн захидалд үйлчлүүлэгчийн үндсэн хөрөнгө болон биет бус хөрөнгүүдэд үнэлгээ, дахин үнэлгээ хийлгэх зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитын төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагналын үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримталсан стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.5, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитыг Төрийн аудитын тухай, Төсвийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан төрийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2018 оны 1 дүгээр сарын 30-наас 2018 оны 3 дугаар сарын 10-ны хооронд хийж, аудитын тайланг 2018 оны 3 дугаар сарын 12-нд эцэслэн баталгаажуулж,

Байгууллагын удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Хүлэгтхүннү аудит ХХК-ийн аудитор Ё.Наранбилэг, Ц.Алтанзул, туслах аудитор Г.Уянга-Од, аудиторын туслах Г.Энхзул, М.Дөлгөөн, чанарын хяналтын менежер Е.Оюундэлгэр нар хариуцаж хэрэгжүүлэв.

Аудитаар Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2018 оны 2 дугаар сарын 12-ны өдөр 1/214 дугаартай албан бичгээр Хүлэгтхүннү аудит ХХК-д ирүүлсэн байна.

2.3 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Шинжлэх ухаан, технологийн их сургууль санхүүгийн үйл ажиллагаандаа Монгол Улсын Төсвийн тухай, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай болон бусад холбогдох хуулиуд, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт /УСНББОУС/, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар, санхүүгийн тайлан, тодруулгын маягт, санхүүгийн тайлан бэлтгэж гаргах аргачлал, "Эдийн засгийн ангилал батлах тухай" зэрэг эрх зүйн актуудыг мөрдөж байна.

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.4, Боловсролын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалтыг үндэслэн Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректорын 2017 оны 02 дугаар сарын 01-ний өдрийн А/15 дугаар тушаалаар 2017 оны албан тушаал, бүтцийг 1870 ажилтны орон тоотойгоор баталсан. 2017 онд 12 сургууль, 2 институт, 1787 багш, ажиллагсадтайгаар, нийт 18000 гаруй оюутан (бакалавр, магистр, доктор, сурагч)-д боловсрол олгох сургалтын үйлчилгээг үзүүлсэн байна.

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл:

- Бакалавр, магистр, докторын (Ph.D) зэрэгтэй мэргэжилтэн бэлтгэх;
- Ерөнхий боловсролын гүнзгийрүүлсэн болон мэргэжлийн анхан шатны боловсрол олгох;
- Дипломын дараах мэргэжил дээшлүүлэх сургалт явуулах;
- Их сургуулийг хөгжүүлэх чиглэл, хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;
- Сургалтын агуулга, арга, хэлбэр, судалгаа, туршилтын ажлын зорилт, чиглэл, тэдгээрийг шийдвэрлэх арга замыг сонгож хэрэгжүүлэх;
- Багш, эрдэм шинжилгээний ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэжилтэн, эрдэмтдийг сонгон шалгаруулж авах замаар профессор багш нарын бүрэлдэхүүнийг сайжруулж, их сургуулийн эрдмийн чадавхийг дээшлүүлэх;

Үйл ажиллагааны стратегийн зорилт:

Үйл ажиллагааны тэргүүлэх чиглэл, эрхэм зорилгын хүрээнд Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт боловсролын талаар тавигдсан үндсэн чиглэлүүдийг хангахын тулд доорх зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Сургалтын агуулга, хэлбэрийг өөрчлөн шинэчилж, зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцүүлэх;

- ШУТИС-ийн хүний нөөцийг болон сургалт, судалгааны материаллаг баазыг бэхжүүлэх;
- Их сургуулийн эрдэм шинжилгээ, технологи, инновацийг хөгжүүлэх;
- Инновацийн түншлэл, гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх;
- Их сургуулийн менежментийг өөрчлөн шинэчилж, хотхоноор хөгжүүлэх;
- Их сургуулийн эдийн засаг, санхүүгийн чадавхийг хөгжүүлэн бэхжүүлэх зэрэг болно.

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн эрхэм зорилго нь нэр хүндээ тогтвортой өсгөж, Азийн шилдэг их сургуулиудын нэг болох зорилгын хүрээнд ажиллаж байна.

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд төлөвлөсөн хэмжээнд судалж, баримтжуулсан.

2.4 Аудитын шалгуур үзүүлэлт, арга зүй, хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудит хийхэд Аудитын олон улсын стандарт, Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810 буюу Санхүүгийн аудитын удирдамж, Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиудыг гол шалгуур болголоо.

Аудитаар Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санал дүгнэлт өгөх зорилгоор тэдний бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн дансдын уламжлалт болон хяналтын эрсдэлийг үнэлж баримтжууллаа.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын 10 чиглэлээр түүвэрчилсэн байдлаар аудитын 33 горим, сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр горим сорилыг хэрэгжүүлэх явцад илэрсэн алдаа, зөрчилтэй зарим гол асуудлыг энэ тайлангийн 2.9 дэх заалтад хураангуйлан тэмдэглэв.

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд эрсдэл бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтний оролцоо шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ.

Шинжлэх ухаан, технологийн их сургууль нь санхүүгийн тайлангаа нягтлан бодох бүртгэлийн "E-FINANCE SYSTEM" програм хангамжаар бэлтгэсэн байна.

2.5 Дотоод хяналт

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь САГ-2018/117/СТА-ТӨҮГ

материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 5 дугаар сарын 16-ны өдрийн хурлын 12 тоот тогтоолоор "Дотоод хяналтын алба"-ыг дарга, дотоод аудитор 2, нягтлан бодох бүртгэлийн мэргэжилтэн 2 орон тоотойгоор баталсан. Уг алба нь одоогоор Геологи, уул уурхайн сургуулийн 2015-2016 онуудын цалин, төсөл гэрээт ажил, цагийн тооцоо, сургалтын төлбөрийн тооцоо, Бизнесийн удирдлага хүмүүнлэгийн сургуулийн 2014-2016 он, 2017 оны эхний 6 сарын төсөв, гүйцэтгэл, цагийн тооцоо, бараа материал, худалдан авалт, үндсэн хөрөнгө, багшийн цаг тооцох журмын хэрэгжилт, цагийн ачаалал зэрэг нягтлан бодох бүртгэл, эдийн засгийн үзүүлэлтүүдийг нэг бүрчлэн шалгаж, тайлан бэлтгэгдэж байгаа болно. Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд бага гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт хангалттай гэж үзлээ.

2.6 Орлого, зардлын талаарх тайлбар, тодруулга

Монгол Улсын Боловсролын тухай хуулийн 36.12.3 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн дүрмийн 3.1.5 дугаар заалт, ШУТИС-ийн Удирдах зөвлөлийн 2017 оны 12 сарын 27-ны өдрийн 08 тоот тогтоолоор төсөвт тодотгол хийж 40,861.9 сая төгрөгийн орлого, 52,341.4 сая төгрөгийн зарлагын төсвийг баталсан байна.

Төсвийн орлогын нийт гүйцэтгэл 6,907.1 сая төгрөгөөр буюу 16.9 хувиар өсөхөд сургалтын орлого 4,239.5 сая төгрөгөөр өссөн нь, мөн банкин дахь мөнгөн хөрөнгийн хуримтлалаас 1,897.1 сая төгрөгийн хүүгийн орлого олсон нь голлох нөлөөг үзүүлсэн байна.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 8,297.6 сая төгрөгөөр буюу 15.9 хувиар буурахад цалин хөлсний зардал 2,671.4 сая төгрөгөөр буурсан нь, мөн төлөвлөсөн хөрөнгө оруулалтын 4,106.8 сая төгрөгийн ажил хийгдээгүй нь голлох нөлөөг үзүүлсэн байна. 2017 онд хичээлийн 8-р байр барих хөрөнгө оруулалтын ажил хийгдэхээр төлөвлөгдсөн боловч ТӨБЗГ-аас 2017 оны 12 сарын 27-ны өдөр холбогдох зөвшөөрөл өгөгдсөн тул тайлант хугацаанд хийгдэх боломжгүй болсон байна.

2.7 Шилэн дансны мэдээлэл

Шинжлэх ухаан, технологийн их сургууль нь Шилэн дансны тухай хуульд заасны дагуу хуульд заасан хугацаанд жил, улирал, сар, тухай бүр оруулах мэдээллийг оруулсан байна. Байгууллагын цахим хуудас <http://www.must.edu.mn> сайтад шилэн дансны цэсийг холбосон. Шилэн дансны сайтад байгууллагын тухайн жилийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг, хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл, худалдан авах ажиллагааны тайланг оруулсан байна.

2.8 Төлөвлөлтийн шатанд тооцсон эрсдэл, түүний үр дагавар

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 10 чиглэлээр эрсдэл тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 33 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Хэрэгжүүлсэн горим сорилын үр дүнг гүйцэтгэлийн үе шатны "Төлөвлөсөн горим, сорилуудыг хэрэгжүүлж, үр дүнг аудитын чиглэл тус бүрээр баримтжуулах" гэсэн үе шатны ажилд хамааруулан ТАБ-СТА-В-3 маягтаар данс тус бүрээр баримтжуулсан болно.

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

2.9.1 Биет бус хөрөнгийн талаар

Арилжааны бус ажил гүйлгээгээр хүлээн авч, ашиглаж байгаа 21 байршил дахь 406.8 мянган м.кв газар эзэмших эрхийг хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй байна. Энэ нь УСНББОУС 31(28)-т "Биет бус хөрөнгийг зөвхөн дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө ... хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн ирээдүйн үр өгөөж буюу үйлчилгээний чадвахийг байгууллага хүртэх магадлалтай ... бодит үнэ цэнийг бодитойгоор хэмжих боломжтой бол" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2018 онд газар эзэмших эрхүүдийг хүлээн зөвшөөрч бүртгэх бодит үнэ цэнийг тогтоох үнэлгээг болон 2018 оны бодит үнэ цэнийг тогтоох дахин үнэлгээг хийлгүүлэх зөвлөмжийг өгсөн.

2.9.2 Үндсэн хөрөнгийн талаар

Дараа үеийн хэмжилтэнд нь дахин үнэлгээний загвар ашигладаг үндсэн хөрөнгүүдэд 2009 оноос хойш 9 жилийн хугацаанд дахин үнэлгээ хийлгүүлээгүй байна. Энэ нь УСНББОУС 17(49)-д "Дахин үнэлгээний давтамж нь дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаалдаг ... бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц тогтмол өөрчлөлт гардаг ... бол ... жил бүр дахин үнэлэх ... бодит үнэ цэнэ нь үл мэдэгдэм өөрчлөлттэй байдаг хөрөнгийн хувьд ... таван жил тутамд дахин үнэлгээ хийх нь тохиромжтой" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2018 онд дахин үнэлгээ хийлгүүлэх зөвлөмжийг өгсөн.

2.9.3 Бараа материалын талаар

Нийт 628.8 сая төгрөгийн бараа материалыг ашиглалтанд тавьж олгосон боловч үл хүлээн зөвшөөрч бүртгээгүй алдааг гаргасан байна (2017 оноос өмнөх хугацаанд 440.9 сая төгрөг, 2017 онд 187.9 сая төгрөг). Энэ нь УСНББОУС 12(44)-д "Бараа материалыг борлуулах, солилцох буюу хуваарилах үед тэдгээр бараа материалын дансны үнийг холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үеийн зардал гэж хүлээн зөвшөөрөх ёстой. Хэрэв холбогдох орлого байхгүй бол барааг хуваарилах буюу холбогдох үйлчилгээг үзүүлэхэд гарсан зардал гэж хүлээн зөвшөөрнө" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2017 оны санхүүгийн тайланд 628.8 сая төгрөгийн алдааг залруулсан.

2.9.4 Авлагын талаар

Барилга шинээр барих, барилгын өртөгт капиталжих өргөтгөл, засварын хийгдэж дууссан бэлтгэл ажил (зураг төсөл, барилгын хашаа г.м)-ын төлбөрт төлсөн 189.9 сая төгрөгийг, хийгдэж дуусаагүй байгаа барилгын засварын ажлын төлбөрт төлсөн 59.1 сая төгрөгийн урьдчилгаа төлбөрийг тус тус авлагаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн, мөн шаардлага хангаагүйн улмаас буцаасан номны 13.7 сая төгрөгийг авлагыг хүлээн

зөвшөөрч бүртгээгүй байна. Энэ нь УСНББОУС 17(30)-д "Үндсэн хөрөнгийн зүйлийн өртөг дараах зүйлээс бүрдэнэ ... үйл ажиллагаа явуулахад бэлэн болгож байршуулах болон шаардлагатай нөхцлийг хангахтай холбоотой шууд зардлууд ...", УСНББОУС 17(24)-д "... хүлээн зөвшөөрөлтийн зарчмын дагуу хүлээн зөвшөөрөлтийн шалгуур хангаж байх үеийн ... орлуулах хэсгийн өртгийг үндсэн хөрөнгийн дансны үнийн хэсэгт хүлээн зөвшөөрнө", СТОУС-ын СҮБ(4.52)-д "... Хөрөнгийг балансад хүлээн зөвшөөрөх шалгуур хангагдахаа болисон үед зардлыг нэн даруй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө", СТОУС-ын СҮБ (ЧШ4)-д "Санхүүгийн мэдээллийг үр ашигтай болгохын тулд үүгээр харуулах зүйлсийг зохистой бөгөөд үнэн зөв илэрхийлэх ёстой" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2017 оны санхүүгийн тайланд 249.0 сая төгрөгийн алдааг залруулсан ба ШУТИС-ийн гүйцэтгэх удирдлагын зүгээс 2018 оны санхүүгийн тайланд залруулах шийдвэрийг гаргасан тул 13.7 сая төгрөгийн алдааг залруулаагүй.

2.9.5 Өмчийн талаар

Ирээдүйн үр өгөөжгүй болж данснаас хасагдсан үндсэн хөрөнгийн 1,013.6 сая төгрөгийн дахин үнэлгээний нэмэгдлийг хуримтлагдсан үр дүн рүү шилжүүлэн бүртгэснийг өмчийн өөрчлөлтийн тайланд толилуулахдаа "нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга" гэсэн үзүүлтэд хамааруулан толилуулсан. Энэ нь Сангийн сайдын 2006 онд баталсан "Төсөвт байгууллагын санхүүгийн тайланг бэлтгэх заавар"-ын 7.4-т "Үндсэн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын дахин үнэлгээний өсөлт/ бууралт болон гадаад дахь байгууллагын санхүүгийн тайланг хөрвүүлэхэд гарсан валютын ханшийн өөрчлөлтийг өмчийн өөрчлөлт гэж үзэн тайланд тусгана" гэж заасныг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: 2017 оны санхүүгийн тайланд 1,013.6 сая төгрөгийн алдааг залруулсан.

2.9.6 Өр төлбөрийн талаар

Урт хугацаат өр төлбөрийн 2018 онд төлөгдөх 5.6 сая төгрөгийн дүнг богино хугацаат өр төлбөрөөр ангилан бүртгээгүй.

Шийдвэрлэсэн нь: ШУТИС-ийн удирдлагын зүгээс 2018 оны санхүүгийн тайланд залруулах шийдвэрийг гаргасан тул 2017 оны санхүүгийн тайланд 5.6 сая төгрөгийн алдааг залруулаагүй.

2.10 Анхаарал татахуйц бусад чухал асуудал

2012 онд Төрийн өмчийн хороо (хуучин нэрээр)-ноос зөвшөөрөл авалгүйгээр Химон ХХК-иас 1,174.2 сая төгрөгөөр, Немон ХХК-иас 462.5 сая төгрөгөөр барилгын зоорийн давхрыг худалдан авсан байна. ТӨХ-ны зүгээс хууль зөрчсөн худалдан авалт гэж үзэж үндсэн хөрөнгөд бүртгэх зөвшөөрлийг өгөхөөс татгалзсан, сургуулийн удирдах зөвлөлийн зүгээс энэхүү асуудал хууль, хяналтын байгууллагад шалгагдаж байгаа ба эцсийн шатны шийдвэр гарах хүртэл ямар нэг шийдвэр гаргахгүй байх шийдвэрийг гаргасан байна.

Аудитын явцад Химон ХХК, Немон ХХК-д авлага тулган баталгаажуулах захидлыг хүргүүлэх ажлыг зохион байгуулсан боловч тэдгээр компанийн зүгээс ШУТИС-д өр

төлбөрийн асуудал байхгүй гэж мэдэгдсэн тул 1,636.7 сая төгрөгийн авлагын үлдэгдлийг баталгаажуулж чадаагүй.

2.11 Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд

2017 оны санхүүгийн тайлангийн аудитаар ажилчдад шүүхийн шийдвэр, захирамжийн дагуу олгосон олговрыг үзэж амжаагүй тул дараагийн аудитаар авч үзэх. Мөн дараа үеийн хэмжилтэнд нь дахин үнэлгээний загвар ашигладаг үндсэн хөрөнгүүдэд болон биет бус хөрөнгүүдэд дахин үнэлгээ хийгдсэн байдлыг авч үзэх.

2.12 Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 1,910.8 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс 1,891.5 сая төгрөгийн алдааг залруулж, 19.3 сая төгрөгийн алдааг залруулаагүй.

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд "СМД аудит" ХХК аудит хийж, "Хязгаарлалттай" санал дүгнэлт гаргаж, 1,839.9 сая төгрөгийн дүнтэй 6 зөвлөмж өгөгдсөнийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

2.14 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар:

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг АОУС320(9)-д "Улсын секторын аж ахуйн нэгж, байгууллага нь улсын эд хөрөнгийг эзэмшин ашиглаж байгаа тохиолдолд хөрөнгө нь материаллаг байдлын тохиромжтой жишиг суурь болно" гэж заасныг үндэслэн санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгийг суурь болгон авлаа.

Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн 2017 оны санхүүгийн байдлын тайлангийн нийт хөрөнгө 89,482.8 сая төгрөгийн 1.0 хувиар буюу 894.8 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

2.15 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон АОУС-д нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайланг материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Зөрчилгүй санал дүгнэлт:

Шинжлэх ухаан технологийн их сургуулийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө /өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан /нийт 20 хуудас/-г хавсаргав.

3 Менежментийн захидал

Үндэсний аудитын газар аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгчид зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүүгийн хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг билээ.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын горимоос урган гарсан болно. Санхүүгийн тайлангийн талаар санал дүгнэлт гаргахад бидний горим зориулагдсан.

Энэ нь Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан санхүүгийн ажилтнуудад талархал илэрхийлье.

Менежментийн захидалд дурдсан зөвлөмжүүд цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг ач холбогдлынх нь дарааллаар эрэмбэлэн дор нэгтгэн харуулав.



3.1 Биет бус хөрөнгийн талаар**Тэргүүлэх ач холбогдол №1****ҮАГ-ын ажиглалт**

Арилжааны бус ажил гүйлгээгээр хүлээн авсан 406.8 мянган м.кв газар эзэмших эрхийг хөрөнгөөр хүлээн зөвшөөрч бүртгээгүй байгаа нь УСНББОУС 31(28)-т "Биет бус хөрөнгийг зөвхөн дараах тохиолдолд хүлээн зөвшөөрнө ... хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн ирээдүйн үр өгөөж буюу үйлчилгээний чадвахийг байгууллага хүртэх магадлалтай ... бодит үнэ цэнийг бодитойгоор хэмжих боломжтой бол" гэж заасныг зөрчсөн байна.

ШУТИС нь газар эзэмших эрхийн хүлээн зөвшөөрөлтийн дараа үеийн хэмжилтэнд дахин үнэлгээний загвар ашиглах бодлого баримталдаг.

Эрсдэлүүд

Санхүүгийн байдлын тайланд биет бус хөрөнгийн дүн дутуу толилуулагдах.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2018 онд хийхээр төлөвлөсөн хөрөнгийн үнэлгээний ажлын хүрээнд газар эзэмших эрхийн хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнийг тогтоох үнэлгээг болон дахин үнэлгээг 2018 онд хийлгэж, үр дүнг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ҮАГ-т ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

2018 онд зөвлөмжийн дагуу 2 төрлийн үнэлгээг хийлгүүлж газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд ҮАГ-т хүргүүлэх болно.

3.2 Үндсэн хөрөнгийн талаар	Тэргүүлэх ач холбогдол №1
------------------------------------	----------------------------------

ҮАГ-ын ажиглалт

Дараа үеийн хэмжилтэнд нь дахин үнэлгээний загвар ашигладаг үндсэн хөрөнгүүдэд 2009 оноос хойш 9 жилийн хугацаанд дахин үнэлгээ хийлгүүлээгүй байгаа нь УСНББОУС 17(49)-д "Дахин үнэлгээний давтамж нь дахин үнэлж буй үндсэн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс шалтгаалдаг ... бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц тогтмол өөрчлөлт гардаг ... бол ... жил бүр дахин үнэлэх ... бодит үнэ цэнэ нь үл мэдэгдэм өөрчлөлттэй байдаг хөрөнгийн хувьд ... таван жил тутамд дахин үнэлгээ хийх нь тохиромжтой" гэж заасныг зөрчсөн байна.

Эрсдэлүүд

Санхүүгийн байдлын тайланд үндсэн хөрөнгийн дүн бодит үнэ цэнээсээ ялгаатай байдал (илүү, эсвэл дутуу)-аар илэрхийлэгдэх.

ҮАГ-ын зөвлөмж

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 2 дахь заалтыг үндэслэн Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2018 онд хийхээр төлөвлөсөн хөрөнгийн үнэлгээний ажлын хүрээнд дараа үеийн хэмжилтэнд нь дахин үнэлгээний загвар ашигладаг үндсэн хөрөнгийн ангийн бүх хөрөнгүүдэд 2018 онд дахин үнэлгээ хийлгэж, үр дүнг нь санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрч бүртгэх.

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2018 оны 9 дүгээр сарын 01-ний өдрийн дотор ҮАГ-т ирүүлэх.

Үйлчлүүлэгчийн хариу

Зөвлөмжийн дагуу дахин үнэлгээний загвар ашигладаг үндсэн хөрөнгүүдэд 2018 онд дахин үнэлгээг хийлгүүлж, үр дүнг санхүүгийн тусгах болно. Зөвлөмжийн хэрэгжилтийг заасан хугацаанд ҮАГ-т хүргүүлэх болно.

4 Аудит хийгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

4.1 Аудит хийгдсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон тайлан
/төгрөгөөр/

Дансны код	ҮЗҮҮЛЭЛТ	ЭХНИЙ ҮЛДЭГДЭЛ	ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ
